

Тулгар төрийн үүсэл, хөгжлийн явцад төрийн
албаны тухай үзэл баримтлал төлөвшсөн нь

Доктор /PhD/ Д.Дайриймаа
/Удирдлагын академийн багш/

Чингис хаан “Мөнх тэнгэр мөхөс миний биеийг зарлигдан түмэн иргэдийг захируулахаар соёрхов. Тал нутагт одоо болтол эмх журамгүй учраас ийм зэрэгт хүрсэн ажээ. Үр хүүхэд, эцэг эхийн үгийг авахгүй, дүү нар нь ахаа дагахгүй, эр нь эхнэрээ итгэхгүй, эхнэр нь эрийнхээ үгийг даахгүй, дагагсад нь ахлагчийгаа хүндлэхгүй, ноёд нь ард албатынхаа дотор үүрэг гүйцэтгэхгүй, баячууд нь ядуусаа тэтгэхгүй, газар сайгүй сэтгэл тайван суухын аргагүй болж, бидний омог аймаг, төрөл угсаатны дэг журам бүр алдагдаж, сүр сүлдгүй болоход хүрч буй. Эдүгээ хүрсэн газар бүхэнд дураараа авирласан хүмүүн олон. Худалч, хулгайч урвагчид, дээрэмчид хүртэл бий болжээ. Иймээс миний бие ард олныхоо хүсэл захиасыг даган энэхүү мөчид хатуу чанга жам ёсоор тэд нарыг засаж, нэгтгэн энх амгалан зол жаргалыг энэ нутагтаан хүртээн тогтоохыг чармайх ёстой.

Миний баясах нь дэлхий дахин нэгэн гэр бүл болж, төв төвшин, энх амгалан болбоос сая миний баясах хэрэг” /1-1501/ “Эргэн тойрон ёс бус олон хаад байна. Тэд эрх дураараа аашилж, олон амьтныг зуун зүйлээр зовоож, үргэлж цэрэглэн байлдаж, хүний үхэх нь элс хийсэхтэй адил болжээ. Иймээс би тэднийг нийтээр энх түвшин болгох бодолтой. Учир нь нэгэн хүн төрөөд түмэн газрыг эмхлүүлэх нь цөм хүн болон төрөгсөдийн тусгай явдал мөн бөгөөд хэрэв чадваас дээд тэнгэрт гавъяа ажээ, доод амьтанд өршөөл ажээ” /1-1501 хэмээсэн зарчмыг чанд баримталж байсан төдийгүй, үр ач нар болон төрийн зүтгэлтнүүддээ дахин давтан сургаж байжээ. Ер нь монголчуудын эртнээс нааш эрхэмлэж ирсэн эв нэгдлийн тухай ойлголт нь Их Монгол улсын үеэс **“Төр нь эв нэгдлийг эрхэмлэн, гүрэн улсаа түвшитгэж, энх амгаланг тогтоох үүрэгтэй”** хэмээсэн төрийн монгол ухаан болтлоо хөгжсөн бололтой.

Чингис хааны үзэж байснаар **төрийн жолоог атгаж, улс орныг мандуулах тэнгэрийн элч /хөвгүүн/ хэзээ нэгэн цагт жам ёсоор заяах учиртай. Тэрхүү элч мөнх тэнгэрийн ивээлээр төрийг төвхнүүлж, улс орныг дотроос нь төвшитгөн тохинуулж, энх амгаланг тогтоон улмаар дэлхий ертөнцийг бүхэлд нь засаглан захирах төртэй болно. Ингэснээр бүх улс, гүрэн даяар дээр доргүй харилцан жаргах ёстой** байжээ.

Чухам ийм үзэл баримтлал Чингис хааны төрийн үзэл баримтлалын тулгуур, стратегийн шугам байжээ гэж үзэх үндэстэй байна. Энэхүү үзэл баримтлал нь нийгмийн хөгжлийн өөрийн нь дотоод эх сурвалж, нөхцөл шалтгаан, зүй тогтол, хэрэгцээний эрхээр улс орны эв нэгдлийг хангаж, энх амгаланг тогтоох замаар төр улсыг төвхнүүлдэгийг мэргэнээр номлож байгаа боловч ертөнцийг бүхэлд нь нэгтгэх гэсэн санаа нь монголын нэгдсэн төрийн гадаад бодлогод биеллээ олж, зарим талаар сөрөг үүрэг гүйцэтгэсэн түүхэн сургамжийг анхаарахгүй өнгөрөх аргагүй юм.

Түүнчлэн төр нь “их багын санааг асуун нэгтгэж, егүүтгэл үгүй сэтгэлийг угаас барьж, шашин амьтны тусын тулд шамдан, хамаг амьтныг ганц хүү шигээ асарч, эцэг мэт сургаж, эх мэт тэжээ” /2-51/ гэх буюу “Хүнийг эзэмдэн жолоодъё гэвэл сэтгэл санаагийг нь эзэмдэх учиртай” /1-1220-1221/ гэсэн зарчим Чингис хааны үндэслэсэн тулгар төрийн үйл ажиллагаанд тууштай баримтлагдаж байсныг түүхэн мэдээ, баримтууд нотолж байна.

Чингис хаан төрийн шадар сайдууд, хан хөвгүүддээ хандаж, төрд хэрэгтэй үгээ хэлнэ үү гэхэд:

“Хаан хүний гучин таван эрдмээр хамагт хандаж
Хас төрийн хууль ёсоор хурц чанга тэгшитгэж
Хамаг улсын үр ач нарыг хүмүүжүүлэн сургаж

Хамт бүх улс иргэнээ амар энх болготугай" /1-1280-1285/
хэмээсэн Боорчийн хариултыг,

"Хэмжээгүй өршөөлөөр өнчин бэлбэсэнийг тэтгэж

Хэмжээт хатуу засгаар ховч бялдуучийг засаглаж

Хэтэрхий их улс төрийг хэв хуулиар засаж

Хэв хэзээд арилшгүй төр ёсыг тогтоомуу" /1-1280-1285/

хэмээсэн Чу мэргэний хариултыг өндөр үнэлж "Хойтод хууль болтугай хэмээн Хөх дэвтэрт" /3-68/ тэмдэглүүлжээ.

Эдгээр баримтаас үзвэл Боорчи болон Чу мэргэний санаатай Чингис хааны санаа нэг байгаа бөгөөд **төр нь нэг талаас шударга, өршөөлт байх, нөгөө талаас харш явдалд хатуу чанга засаглах ёстой** гэсэн номлол болох нь харагдаж байгаа бөгөөд бүр хуульчлан тунхаглажээ гэж үзэж болохоор байна.

Отчигин ноён /Чингис хааны отгон дүү/ Чингис хаан буюу ахдаа бараалхаад буцаж явахдаа Гоо сэцэнтэй тааралдаж "Хан хүний улс засаглах ёсон ямар вэ?" хэмээн асуухад Гоо сэцэн "Хан хүний улс засаглах ёсон нь наран мэт үл хождуулах, нуур мэт үл голон хатуужих буюу хэмээсэн ажээ". Энэ үгийн утгыг Отчигин ноён 3 хоног бодоод тайлж чадаагүй учир дахин Гоо сэцэнд хандаж, тайлж өгөхийг хүсчээ. Гоо сэцэн зөвшөөрч "Хан хүнийг наран мэт бүү хождуул хэмээх минь наран ургаваас сайн ба мууд, амьд ба үхсэнд тэгш халуун гэгээгээ хүргэюү. Хан хүн тэр мэт тэгш сэтгэлт болбоос их улсын дуран яахин үгүй болох. Нуур мэт бүү гол хэмээх минь нуурт сайн ба муу бээр усанд орьюү. Сайн муу адгуусан усан ороод буртаглаваас нуур тэд бүгдийг үл голон шингээюү. Хан хүн тэр мэт сэтгэж, сайн муу бээр үг сонсвоос үнэн худал, зангүхэн үгс сонсвоос өргөс хатгах үгэнд үл орон тэгш болгож сонсвоос их улс яахин эвдрэх хэмээсэн ажгуу" /3-108/

Энэхүү баримтаас үзвэл төр нь хайр халамж, ял цаазаа хэн бүхэнд тэгш эдлүүлж, хаад ноёд харц ядуус, өштөн дайсан хэний боловч санаа бодлыг бүрэн сонсож, авах гээхийн ухаанаар хандвал эвдрэл тэмцлийг хазаарлаж болно гэсэн үзэл баримтлал ил харагдаж байгаа бөгөөд XIII зууны үед монголын нийгэм-төрийн сэтгэлгээнд нэвт шингэсэн баримтлал болох нь харагдаж байна.

Өнчин хөвгүүн есөн өрлөгтэй цэц булаалдан есөн өрлөгийн зарим нь өнчин хүү бидэнтэй эн зэрэгцлээ гэж эгдүүцэн байхад харин "Эзэн богд өнчин хүүгийн үгийг бүрэн сонсож, дэргэдээ аван ёст хувцас өмсгөн, хишиг хүртээж байжээ." /3-90/

Бас "Хунан, Хөхөчос, Дэгэй, Үсүн өвгөн энэ дөрвүүл үзсэнээ нуухгүй, үнэн үгээ хэлж, мэдсэнээ мэлзэхгүй, сонссон үгээ сонсгодог билээ" /4-188/ хэмээн соёрхол хүртээж байжээ. Эдгээр мэдээ баримтаас үзэхэд Чингис хаан харц ардуудаас эхлээд хаад ноёд, түшмэдүүдээсээ төрийн үйл хэргийн талаар асуун ярилцаж, тэдний оюун ухаан, сэтгэхүйн чадварыг тэнсэн хөгжүүлэх давхар зорилго бүхий цэц булаалдах маргаан, шүүн тунгаах ярилцлага явуулах зэргээр санаа бодлыг нь мэдэж, үнэтэй санаа бодол хэлсэн хүнийг хөхүүлэн урамшуулдаг байсныг дээрхи баримтууд нотолж байгаа юм. Чингис хаан хэдийгээр хэмжээгүй эрхт хаан байсан боловч **олонтой найран зохилдож, олноор шийдсэнийг эвдэхгүй** гэсэн зарчмыг тууштай баримталж тулгар төрийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж байсан нь орчин үеийн ардчилсан төрийн нэн чухал шинж үндэслэгджээ хэмээн үзэж болохоор байна.

Түүнчлэн Чингис хаан "Төр улсынхаа цаашдын хувь заяаны тухай бодлого боловсрулахдаа юуны өмнө өөрийн төрийн дор нэгдсэн олон овог аймгийн хүмүүс чухам юу бодож сэтгэж байдгийг судлан үзэж тэр үед монголчууд энх түвшин, баян чинээлэг, жаргал цэнгэлтэй амьдрахыг хүсч байсан тухай олж тогтоож байсныг" /5-88/ доктор Ч.Жүгдэр судалгааныхаа бүтээлд тэмдэглэсэн байна.

Энэ бүхнээс үзвэл Чингис хаан **төр нь олон түмэндээ тулгуурлан хүч олж, олон түмэн нь төрийнхөө ивээл дор энх амгалан, эрх жаргалтай аж төрж чадваас төр, иргэний бат холбоо тогтож, төр ёс түвшин байх болно** гэсэн үзэл бодлыг хөгжүүлсэн байна. Нэг үгээр хэлбэл **түмэн олныг толгойлох төр нь**

ард олондоо эцгийн түшиг, эхийн элбэрэл үзүүлэх үүрэгтэй бөгөөд эл үүргээ биелүүлэхийн тулд тэдний санаа бодлыг сайтар мэдэж, хэрэгжүүлэх бодлого, хийх ажлынхаа чиг, хандлагыг тогтоох учиртай гэсэн баримтлал Монголын тулгар төрийн бүхий л бодлого, үйл ажиллагаанд шингэсэн байжээ хэмээн үзэж болохоор буюу.

Чингис хаан “бие баатар болбоос нэгээхэн үеийн баатар буюу, билиг баатар болбоос түмэн үеийн баатар буюу. Та нар эрдэм билигт хүнийг олбоос эрдэнэ өгч, улмаар ойртон шадарлаж хүчийг нь хэрэглэвээс ач тус нь их болно” /1-1559/ хэмээн төрийн албаны ноёд түшмэдүүдээ байнга сургадаг байжээ. Тэрээр өөрийн болон бусад орны эрдэмтэн мэргэдийг олж, ойр дөт холбоо тогтоох, урьж зөвлөлгөө авах, тодорхой албан тушаалд ажиллуулах замаар төрийн хэрэгт ашигладаг байсан байна. Тэгэхдээ тэдний авъяас чадварыг үнэлж, өндөр шан харамж хүртээх, дээд зиндааны боллоцоо нөхцлөөр хангах зэргээр бүх талаар хөхүүлэн урамшуулж чаддаг байсан нь тэр үеийн суу билигтнүүдийг төрийн хэрэгт татан оруулах хүчтэй соронз болж байсан ажээ. Кидан гарлын эрдэмтэн Елюй-Чу-Цай, Найманы Тататунга, Сүн улсын Даосын Бомбо лам гэх мэт олон эрдэмтэн мэргэд тэрхүү соронзонд татагдаж монголын төрд чин үнэнчээр зүтгэж байсныг түүхэн баримтууд гэрчилнэ.

Чингис хаан “Сэцэд мэргэдийн сэлбэн холбон өгүүлсэнийг хойтод хууль болтугай хэмээн дэвтэрлэн” /3-129/ үлдээхийг зарлиг болгож, тухайн үеийнхээ авъяас билигтнүүдийн оюуны бүтээлийн дээжисийг нэгтгэн хойч үедээ үлдээсэн нь “Билиг сургаал” нэртэйгээр бидний үед уламжлагдан ирсэн байна. Энэхүү “Билиг сургаал” нь тэр үеийн олон арван ухаант мэргэдийн оюуны хамтын бүтээл төдийгүй монголын нэгдсэн тулгар төр арга билгийн хүчийг хэрхэн үнэлдэг байсны нэгэн баримт болж үлдсэн юм.

Өгэдэй хаан Хархорумд гэрийн сургууль байгуулж Иран, Энэтхэгийн эрдэмтдийг урьж ирүүлэн төрийн албаны хаад, ноёдод олон төрлийн хичээл заалгаж байсан хийгээд Мөнх хаан их эрдэмтэн Насердин Тусыг бүх багаж хэрэгсэлтэй нь Хархорумд ирүүлэхийг хүсэж байсны дээр өөрөө Эвклидийн геометр судалж, геометрийн ном бичиж байсан, 4-5 улсын хил мэддэг байсныг алдарт жуулчин Рубрук тэмдэглэн үлдээжээ. Тэрчлэн XII-XIII зууны үед хааны ордонд Шигихутуг, Хөхчөс, Чинай, Чингай, Хадаг зэрэг 4-5 улсын хэл мэддэг, өндөр боловсролтой олон хүн төрийн алба хашилцаж байжээ. Хувилай хаан сонгон шалгаруулалтаар элсэлт хийдэг “Төрийн сургууль” байгуулж, хятадын төрийн албаны туршлагатай түшмэдүүдээр эзэнт төрийн тогтолцоо, түүний бүтцийг боловсруулах үүрэг өгч гүйцэтгүүлж байсан зэргээс Чингис хаан хүний оюун ухаан, авъяас билгийг дээдлэн төрийн хэрэгт ашиглаж чаддаг байсан чанар түүний залгамжлагчдад нэгэн адил уламжлагдсан байгаа нь харагдаж байна.

Энэ бүхнээс хүний оюун ухаан, авъяас билгийг хөхүүлэн дэмжиж төрийн үйл хэргийг эрдэм ухаан, аргабилгийн эрхээр шийдвэрлэх явдал XII-XIII зууны үеийн монголын төрийн уламжлалт үзэл баримтлалын нэг байжээ гэсэн дүгнэлт хийж болохоор байна.

Түүхэн сурвалжууд болон эрдэмтэдийн судалгааны бүтээлүүдээс үзэхэд Их монгол улсын үед **төрийн албан хаагчийг сонгож олох, бэлтгэн боловсруулах, сургаж дадлагажуулах, дэвшүүлж бууруулах буюу төрийн албаны хүний нөөцийн асуудлаар** өмнөх үеийнхээ төр ёсны уламжлалд тулгуурласан үзэл баримтлал төлөвшжээ гэж үзэж болохоор байна.

Чингис хаан эрт үеэс монгол түмний нийгэм-улс төрийн сэтгэлгээнд биеллээ олсон “Улс төрийн мандан хөгжих цаг болбоос эзэн гэгээн, сайд мэргэн, түмэн иргэн ээвэргүү, харин бууран доройтох цаг болбоос зусар зальхай сайд, янаг дотно хатан эрх барилцаад улс гэрийг самууруулах буюу” /1-437/ **хэмээсэн мэргэн сургаалийг иш үндэс болгон төрийн албанд төгс чадамгай, төв шударга түшээ нарыг төр өөрөө бэлтгэн боловсруулах учиртай хэмээн үздэг байжээ.**

Тэрээр “Эрдэм өршөөлт сайн эзэн улсын эрдэнэ, чадвартай сайд улсыг байгуулахын эрдэнэ, чанга цааз, цэнгэлт шан захирахын сүр, чигч жонон, чадамгай жанжин чанадасыг дийлэхийн үндэс” /1-667/ хэмээн сургаж төрийн алба хашигчдыг сурган боловсруулах талаар онцгой анхаарч байсныг түүхэн сурвалжуудад тэмдэглэжээ. “Хэн өөрийн аж байдлыг сайн зохиож чадвал тэр харъяат улсаа захирч чадна. Аравтыг захирч чадсан хүнд зуут мянгат, түмтийг захируулж болно. Өөрийн арваныг захирч чадаагүй аливаа ноёныг гэмтэн болгож арваны дотроос хэн чадахыг сонгож ноён тавина. Түм, мянга, зууны ноёд үүн лүгээ адил” /5-129/ хэмээн Их засаг хуулийн засаг захиргааны эрхийн хэсэг дотор заасныг доктор Ч.Жүгдэр судалгааныхаа бүтээлд тэмдэглэжээ.

Энэ баримтаас:

1-рт. Төрийн албан хаагчийг сонгож олох, дэвшүүлэх бууруулах буюу сонгох, томилох асуудлыг улсын гол хууль болох “Их засаг”-таа хуульчилж байсныг;

2-рт. Төрийн албан хаагчийг сонгож олохдоо хувийн амьдрал ахуйгаа хэрхэн зохион байгуулж чадаж байгаагаас нь эхлээд төрийн тодорхой албанд сурч дадлагажсан байдлыг нь анхаарч байсан;

3-рт. Аравт, зуутаас эхлээд шат дэвшүүлэн томилж, сургаж дадлагажуулж байсны дээр, хэрэв томилогдсон албаа хашиж чадахгүй бол хуулиар хариуцлага тооцож байсныг;

4-рт. Тухайн албыг хашиж чадах дадлага туршлагатай хүнийг л төрийн албанд дэвшүүлж байсныг харж болохоор байна.

Ерөөс төрийн алба хаших эрдэм чадвартай бол “сармай дээлтэд ч ноёны суудлыг олгоно” /3-129/ гэсэн зарчмыг Чингис хаан тууштай баримталж, тулгар төрийн албанд хэрэгжүүлж байсан байна. Төрийн хэрэгт үнэнчээр зүтгэсэн хоньчин, адуучин хэд хэдэн иргэнийг мянганы ноёноор томилсон баримт Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн байна.

Их монгол улсын үед Чингис хаан хийгээд түүнийг залгамжилсан хаадын үед монголын тулгар төрийн алба хаших хаад, ноёд, түшмэлүүдийг шилж сонгохдоо:

Өнөөдрөөс маргаашаа олж харах холч ухаан, төрийн төлөө бие сэтгэлээ зориулах эр зориг, хүнийг халамжилж, сэтгэлийг нь эзэмдэх чадвар, чин шударга айл араншин, байхгүйг бий болгох, болохгүйг болгох сэтгэл зүтгэл, бичиг эрдмийн боловсролыг юу юунаас эрхэмлэн үздэг байжээ. Эдгээрээс бичиг эрдмийн боловсролоос бусдыг нь төрийн түшээдийн ноён нуруу хэмээн үзэж байсан бөгөөд энэхүү ноён нуруу бат суусан хүнд бичиг эрдмийн болон харвах дайтах чадварыг эзэмшүүлж болно гэж үздэг байсан нь нэн сонирхолтой санаа юм. Бидний орчин үеийн практик үүний эсрэг байгаагаар төрд нөхөшгүй алдаа болсоор байгаа билээ. Хэд хэдэн дээд сургууль дүүргэсэн, эрдмийн зэрэг цолтой олон хүн олигтой түшээ болж чадахгүй байгаа нь бидний бурууг харуулж байгаа баталгаа юм.

Өнөөдрөөс маргаашаа олж харах холч ухааныг монголчууд хэзээнээс дээдэлж ирсэн бөгөөд зөвхөн эрдэм номд төгс боловсорсон хүнийг ухаанд тооцдоггүй байжээ. Харин өөрийгээ болоод орчноо бодитой ухаарч, учир шалтгааныг ургуулан бодож, голч ухаанаар тайлж, түүнийгээ амьдрал ахуйдаа ашиглах, ур дүйтэй, ямар ч нөхцөлд өөрийгээ болон өрөөлийг зөв залах чадвартай, бусдын төлөө өөрийгээ золиослох хэмжээнд төлөвшсөн хүнийг ухаанд тооцож иржээ. Чухам ийм л чанарыг эзэмшсэн хүн өнөөдрөөс маргаашаа, өөрөөсөө бусдыг харах чадвартай болдог ажээ. Тухайлбал **орой жаргасан нарнаас маргааш болох өдрийг тодорхойлж, өчигдөр эдэлсэн жаргалаа нөгөөдөр юунд хүргэхийг мэдэрч, өнөөдөр гаргасан алдаагаа дахин давтдахгүй, бусдын зовлонгоор өөрийгээ жаргаахгүй байна гэсэн үг.** Ийм чанар байхгүй төрийн түшээ, төр, улс, ард түмнийг юман чинээ боддоггүй ажээ.

Харин төрийн албан тушаал, хэргэм зэргийг хар амиа хоохойлох зэвсэг болгон хувиргадаг хэмээн үзэж, хүний ноён нуруу, хүн чанарыг юу юунаас илүү дээдэлж иржээ.

Төрийн албан хаагч нарт ухаанаас гадна төрийн үйл хэргийн төлөө бие сэтгэлээ зориулах эр зориг чухал хэмээн үзэж, энэхүү шалгуураар шалгаж байжээ. Энэ нь төрийн үйлийн төлөө алтан амиа өргөх хэмжээнд шулуудсан байхыг ойлгож байсан байна. Төрийн албан хаагч нь өөрийнхээ бие оюуны бүх чадавхийг бодитой тооцож, эх орон, ард түмнийхээ төлөө өөрийгээ зориулах үүргийг гүн гүнзгий ухамсарласан байхыг ойлгож байжээ.

Чухам тиймээс ч тулгар төрийг үндэслэгч Чингис хаан **“Алд бие минь алжаавал алжааг. Ахуй төр минь бүү алдартугай. Бүрэн бие минь зовбоос зовтугай. Бүрэн улс минь бүү сандартугай.”** /3-123/ хэмээн сургаж байсан бол Улсын ван Мухулай цэрэг дайчиддаа хандан “Чухал үгийг уудам цагт хэлнэ. Нарийн аргыг сул цагт боловсруулна. **Хэрэв намайг үхвээс тэнгэрийн ёр, газрын бэлгэ хэмээн битгий цэрэг саатуул, улсын чухал хэргийг юуны өмнө бүтээхийг санах хэрэгтэй”** /1-1672/ хэмээн сургаж байсан байна. Гэтэл түүний хүү цэргийн жанжин Булу тайж Өгэдэй хаанд хандаж **“Архи, өнгө, жаргал цэнгэлийг хэмжээнээс хэрхэвч үл хэтрүүлмүү. Миний их хүү Тас өнгөнд шунахай, жаргалд бахтай тул хааны хишгийг юуны удаан хүртэх аж. Намайг үхэв хэмээн миний гашуудалд улсын хэргийг үл саатуулмуу”** /1-2099/ хэмээгээд нас баржээ.

Эдгээр баримт нь Их монгол улсын үед төрийн албан хаагчид нь эзэн хаанаасаа эхлээд сайд, ноёд, жирийн тайж хүртлээ өөрийн амь бие, үр хүүхдийнхээ эрх ашгийг үл хайхран зөвхөн төрийн үйл хэргийн төлөө шулуудан ажиллаж байсны баталгаа гэж үзэхээс өөр аргагүй.

Өнөөдөр бидэнд, манай төрийн түшээдэд хамгийн их дутагдаж байгаа зүйл бол чухам ийм чанар юм. Ингэж төрийн хэрэгт бие сэтгэлээрээ шулуудаагүй төрийн албан хаагч нь зөвхөн хар амиа түшиж, улс орон, ард түмнийг хохироодог жамтайг манай дээдсийн мэргэн ухаан тунгаан үзэж төрийн бодлоготоо хэрэгжүүлж байсан байна.

“Хаан хэмээгч ерийн зэрэг хэргэмийн адил дураар хэлж үл болох, үнэн хаан хэмээгч хаан хэмээх нэр өгөлгүйгээр аяндаа олны сэтгэл хаан мэт үзнэ. Үүнийг сая хаан гэнэ.” /1-1241/ **“Хаан бус боловч харин хааны явдлаар явбаас амттай бус уу. Хэрэв хаан болоод хааны явдлыг алдваас хаан болж юу хийх вэ? Өчигдөр сая сууриндаа сууж хаан болмогц өнөөдөр улсын хэргийг орхиж, биеийн жаргалыг эрвээс эдүгээд их төрд харш, хойтод үр ач нарт муу суртал болно”** /1-1265/ гэсэн Чингис хааны айлдвар XIII зууны үеийн монголын төрийн зүтгэлтэн бүрт нэвт шингэсэн байсныг түүхэн сурвалжуудаас харж болно. Их хааны тэртээ XIII зуунд сургаж байсан сургаалийн ач холбогдол тухайн үеийн байсангүй, өнөөдөр ч төрийн албан хаагч бүрийн орой руу ортол хэлсэн мэргэн сургаал буюу. Тухайлбал **төрд алба хашина гэдэг нь сонгууль, томилолтоор албан тушаал олж авсаныгаа би төрийн түшээ болчихлоо хэмээн ойлгож, сонгууль томилолтын хугацаа элээхийн нэр биш, харин үйл ажиллагаа үзэл бодол, хичээл зүтгэлээрээ тэрхүү албыг хашиж чадахаа харуулахад орших бөгөөд харуулж чадвал чамайг олон түмэн аяндаа төрийн түшээ мөн хэмээн хүлээн зөвшөөрнө** гэсэн үг болох нь тодорхой.

Өнөөдөр манайд өвөг дээдсийн маань энэхүү мэргэн ухаан гээгдэж намайг сонгоод, томилоод өгөөч хэмээн албан тушаалын гуйлга гуйж, бүтэхгүй бол наймаагаар албан тушаал авдаг хэтэрхий арчаагүй арга ухаан газар авч байгааг ухаарууштай.

Монголчууд эртнээс нааш чин шударга айл араншинг эрхэмлэн дээдэлж, үр ачаан тэгж хүмүүжүүлж ирсэн ухаан нь төрийн бодлого түшээ нараа сонгох ухаан болж хөгжсөн хэрэг. Ийм учраас XIII зууны үеийн монголчуудын нийгэм-улс төрийн сэтгэлгээнд “Мандах төрийн сайд түшмэл өөрийн гэмээ илэрхийлэн үзүүлмой, буурах төрийн эзэн түшмэл өөрийн гэмийг халхалж арилгамой” /1-437/ хэмээсэн үзэл санаа нэвт шингэсэн байгааг харж болно.

Энэ бүхэн нь Чингис хааны төрийн тухай үзэл бодолд өвлөгдөн **“өөрийн гэмийг бусдаас асууж мэд, төр ёсны ослыг сэцдээс асууж сурсугай. Хэрэв өөрөөсөө бусдыг буруутгаж, гэмээ хэлсэн хүнд өширдөг хүн төрийг сайнаар түшиж**

чадахгүй” хэмээн үзэж байсан байна. Монголын нэгдсэн тулгар төрийн үед **төр шударга биш олон түшээтэй болбол ямар ч шударга хууль цаазыг шударга бусаар үйлчлүүлж, ард олныг чирэгдүүлж, авилгалд өртөж, хов жив, холион бантангийн эзэн болдог хэмээн үзэж**, шударга биш, ноёд, түшмэлүүдийг хатуу ширүүн цээрлүүлдэг байсан хийгээд, үнэнч шударгын үлгэр жишээ болсон олон хүний нэр түүхэн сурвалжуудад тэмдэглэгдсэн байна. Тэрчлэн Чингис хаан эзэн, төрдөө үнэнч шударгын үлгэр жишээг үзүүлсэн дайснаа хүртэл үнэлж бүр ойр дотно нөхөрлөж, төрийн алба хашуулж байсны нотолгоо нь алдарт жанжин Зэв, Алтан улсын цэргийн жанжин Ванзай нарыг хэлж болох бөгөөд өөртэйгээ хамгийн хатуу ширүүн тэмцсэн зоригт хан хөвүүн Джелал-ад-Дин-ийг хэрхэн үнэлж байснаас тодорхой байна.

Монгол түмэн байхгүйг бий болгох, болохгүйг болгож чаддаг тууштай сэтгэл зүтгэлийг дээдэлж шүтэж ирсэн уламжлалтай ард түмэн юм. Нүүдлийн соёл иргэншлийн эрхээр монголчуудад заяасан нэгэн нандин чанар бол хэрэглэх гэж хүссэнээ өөрөө бүтээж, бүтээснээ хамгийн ухаалгаар хэрэглэдэг явдал юм. Монголын тулгар төрийн үед монгол хүний энэ чанарыг төрийн хэрэгт илүү чадмаг ашиглаж байсан төдийгүй ийм чанарыг төрийн түшээ нарыг шилж сонгох нэгэн шалгуур болгож байжээ.

Өөрөөр хэлбэл төрийн өмнө хүлээсэн үүргээ ямар ч нөхцөлд ягштал биелүүлэх эрэлч сэтгэлгээ, тууштай зүтгэл бүхий хүнийг олж төрөө түшүүлж байсан хэрэг. Ийм чанарыг эзэмшээгүй хүн бол ажиллах нөхцлөө бэлнээр нь нэхэж тохиолдсон бэрхшээлийг хэн хэзээ арилгаж өгөх бол хэмээн горилон суудаг, зорилго ч тавьдаггүй, зорьсондоо ч хүрдэггүй ажээ.

Их Монгол улсын үед тулгар төрийн албанд түшээ нараа сонгож авахдаа дээр дурьдсан шинж чанараар дэнсэлж байсны хамгийн тод баримт нь Чингис хааны орыг Өгэдэй шууд залгамжилсан явдал юм. Феодлын сонгодог харилцаа монголд төдийгүй дэлхийн түвшинд ноёрхож байсан тэртээ XIII зууны үед хаан ширээг ууган хүү нь залгамжилдаг ёсыг Чингис хаан яагаад баримтлаагүй вэ? Ууган нь болохгүй юм бол хамгийн хайртай, гал голомтоо сахих заншлын эзэн болох отгон хүү Тулуй нь хаан ширээг залгамжилж болоогүйн учир юу вэ? Эдгээр асуулт судлаачдын сонирхолыг зүй ёсоор татаж, судалгаа хийж санал дүгнэлт хийсээр ирсэнийг мөшгин үзвэл Ууган хүү Зүч нь өөр цустай байсан байж магадгүй бөгөөд тэр нь хүүхдүүдийг нь эвдрэл тэмцэлд хүргэж болзошгүй гэж үзсэн Чингис хааны болгоомжлолоос болсон хэмээсэн санал тайлбар голлосон байна.

Бидний үзэж байгаагаар Өгэдэй их хааны суурийг шууд залгамжилсан гол шалтгаан нь Зүчийн цусан барилдлагаатай холбоотой байж магадгүй боловч тэр үед төрийн түшээг сонгон цэгнэж байсан гол чанарууд Өгэдэйд илүү цогцолж байсанд оршиж байгаа юм биш байгаа гэсэн эргэлзээнд хүргэж байгаа юм. Тухайлбал Өгэдэйн хүнлэг чанар, уужим тавиун сэтгэл, хүмүүсийг татах чадвар, аливаа хорт явуулагад автахааргүй цэх, шулуун, шударга, хүсэл тэмүүлэл төгс, шаардлагатай үед хатуу байр суурь баримталж чаддаг, бичиг эрдэмд боловсорсон байдлаараа бусад хан хөвүүдээс хэнтэй нь ч зүйрлэхээргүй илүү байсныг Чингис хаан төдийгүй тэр үеийн төрийн зүтгэлтнүүд, алтан ургийн хаад ноёд мэддэг төдийгүй хүлээн зөвшөөрч байсан олон баримт мэдэгдэж байгаа юм. Чингис хаан хөвгүүдтэйгээ төрийн хэрэг ярилцах, асуулт тавьж сонсох, хүнд хүчир албанд томилох, зарим тохиолдолд бор дарс уулцаж хүртэл олон янзаар туршиж, цэгнэн үздэг байсан байна.

Чингис хаан нэгэн удаа дөрвөн хөвгүүнээсээ зол жаргалын дээд юу вэ? хэмээн асуухад хөвгүүд нь янз янзын хариулт өгчээ. Тэр дотроос Өгэдэй “Надад ухваас суут хаан эцгийн зовон зөөсөн их улсыг амруулан хөл хөсөр, гар газар тавиулж улс иргэнээ уртад агуулж, төр ёсоо төвшин барьж, өтгөс ихсийг жаргуулж, өсөх залуусыг амруулбаас жаргалын сайн энэ амой” /1-437/ гэснийг машид үнэлж, хан хүний хэлэх үг хэмээн үзэж байсан байна. Энэ нь нэг талаар Өгэдэй залуу насандаа өргөн цар хүрээтэй сэтгэдэг, төр ёсонд ихээр боловсорч байснаараа бусдаасаа ялгарч байсны баримт юм. Чухам ийм учраас Чингис хаан амьд ахуй цагтаа Өгэдэйг өөрийн залгамжлагчаар гэрээсэлж, алтан ургийнхан түүнийг ёсоор болгосон байна.

Өгэдэйн их хааны сууринд суугаад хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаа нь түүнд цогцолсон төрийн түшээ хүний шинж чанар улам бүр илүү тодорч, Чингис хааны сонголт зөв байсныг баталсан олон баримт дурьдаж болох юм.

Өгэдэй эцгийн суурийг 13 жил залгамжлахдаа “Хил гаалийн цааз тогтоон түүнийг захирах түшмэдүүдийг ажиллуулж, малын бэлчээрийг усжуулах, сургууль соёлын газар, судар бичгийн хүрээлэн байгуулж түүх шастир, цаг улирлын бичиг зохиох, эрдэмтэн, мэргэдийг төрийн хэрэгт өргөнөөр татан оролцуулах, улсын нийслэлийг өргөтгөн хөгжүүлэх, өртөө зам байгуулж харилцааг өргөтгөсөн зэрэг өргөн цар хүрээтэй, ухаалаг бөгөөд улс орны хөгжлийн ирээдүйг харсан олон арга хэмжээ авч хэрэгжүүлсэн” /4-253/ бөгөөд энэ тухай түүхэн сурвалж “Монголын нууц товчоо”-ны 281-р зүйлд тэмдэглэгдэн үлдсэн байна.

Тэрээр “Чи бол өдөр шөнөгүй миний улс төрийн тул бодож, явдаг мэргэн бат сайд мөн. Бусад адил эрхтэй сайд түшмэдийн дургүй хүрэх болов уу гэж огт бодохгүй л шууд хэлдэг бөгөөд би ч өөрөө дур зоргоор хэд хэдэн удаа засаг хуулийг зөрчихөд эрхбиш ирж хориглох нь эзнийг үл үтээрхэн ташимгай хэлбүүг үл хэрэглэх чин үнэн нь илрэв. Энд тэнд болж буй болохгүй зохисгүй зүйлүүдийг ил шууд хэлж цөм өөрийн муу болохоос үл зайлан улс төрийн тул бодсон шударга газар болой” /1-2141/ хэмээн Елюй Чу-Цайг үнэлж байсан байна. Энэ баримт нь

1-рт. Елюй Чу-Цай төрийн хууль цаазын өмнөөс хаад ноёд, харц ард хэнтэй ч нэгэн адил ял хэлэлцэж чин шударгаар ажиллаж байсныг

2-рт. Ийм байдал нь Өгэдэйд таалагдаж байсан төдийгүй хаан өөрөө ч Елюй Чу-Цайн ял зэмлэлийг хүлээн зөвшөөрч, даган биелүүлж байсныг баталж байна.

Түүгээр ч үл барам өөрийн алдаа дутагдлыг шударгаар хүлээж түүхэнд тэмдэглүүлсэн ганц л хаан байгаа нь Өгэдэй юм. Тэрээр “Хаан эцгийн их сууринд сууж, олон улс иргэнийг захирах их үүргийг хүлээсэн байтал бор дарсанд орсон минь нэгдүгээр буруу болов. Хоёрдугаарт ёсгүй эм хүний үгэнд орж Отчигин авгын харъяат нарын дотроос хүүхэн авчруулсан буруу болов. Улсын эзэн хаан байтал ёсгүй муу ажлаас үйлэнд автсан минь бас нэг буруу болов. Гуравдугаарт. Доголху-г далдаас хардсан нэг буруу бий. Ямар буруу вэ? гэвэл хаан эцгийн минь харах нүдний өмнө хамгаас түрүүнд хатгалдаж явсан Доголху-г хорт муу үгэнд орж хороожээ. Дөрөвдүгээрт. Тэнгэр газрын заяагаар төрсөн гөрөөсийг бусад ах дүү нарын нутагт очих болуузай гэж харамлан шавар хэрэм бариулж ах дүү нараас гомдох үгийг сонсов. Энэ бас нэг буруу бий.” /4-253/ хэмээн гэмшин байсан нь “Монголын нууц товчоо”-нд тэмдэглэгдэн үлджээ. Рашид-Ад-Диний тэмдэглэн үлдээснээр тэрээр хаан төр жолоодох үндэс, улсын мандан бадрахын суурь тавих талаар ямагт санааширч хэн нэгний санал зөвлөлгөөг хэзээ ч анхаарахгүй орхидоггүй байжээ. Нэг сайдаас энэ ертөнцөд хамгийн сайхан хот ямар хот вэ? гэхэд нөгөө сайд нь Их голын эрэг дээрх “Багдад” хот мөн гэжээ. Тэгвэл Орхон голын эрэг дээрх Хархорум хот илүү сайхан байх ёстой хэмээн хотыг хөгжүүлж байсан байна.

Өгэдэй хаан зах зээл, сүм хийдээр байнга явж хүмүүстэй уулзаж үзсэн харсан болон сонссоноо ажил болгодог байсан тухай мэдээ байдаг. Бас гудамжны гуйлгачинд хатныхаа алтан эзэмэг, бөгжийг авч өгч байсан, ядуу хүмүүсийн урласан бүтээлийг өндөр үнээр худалдан авдаг байсан зэрэг сонирхолтой олон мэдээ сэлт олддог.

Түүнчлэн түшмэл, Баядай, Гүюг нарын хүмүүст харгис хэрцгий аашилсаныг хатуу зэмлэж байсан болон өнчин бэлбэсэнийг тэтгэх улсын сан байгуулж байсан зэрэг нь түүний хүнлэг, ухаалаг зан чанарын гэрч юм.

Энэ бүхэн нь Их монгол улсын үед Чингис хааны үндэслэсэн нэгдсэн тулгар төр нь төрийн алба хаших бие бүрэлдэхүүнийг шилж сонгох, сургаж хөгжүүлэх, үнэлж урамшуулах цэгцтэй номлолтой байсан бөгөөд түүнийгээ хэрэгжүүлж чаддаг байсныг баталж байна. Энэхүү номлолын агуулга ач холбогдол өнөөдөр ч хэвээрээ байгаа төдийгүй төрийн албанд шууд уламжлан хэрэгжүүлэх шаардлагатай юм. **Төрийн албанд ийм бодлого, шалгуурыг хэрэглэж чадвал төрийн албыг аливаад төгс чадамгай, төв шударга түшээ нараар бэхжүүлж, төрийн үйл хэргээс сул дорой**

худал хуурмагийг таягдан хаяж нүсэр биш цомхон хүчинд дулдуйдаж, чин шударга, зоримог дайчин үйл ажиллагаа явуулах бололцоотой болдогийг манай өвөг дээдсийн ухаан, өнөөгийн амьдрал аль аль нь батлан харуулсаар байна.

Ашигласан ном, зохиол

1. Инжаннаш. Хөх судар. I, II, III. Өвөрмонгол хэвлэл.
2. Оюунтүлхүүр. Ц.Дамдинсүрэн. /Зуун билиг оршивой/. УБ., 1959
3. Лувсанданзан. Алтантовч. УБ. 1990.
4. Монголын нууц товчоо. /Ц.Д/ УБ., 1990.
5. Ч.Жүгдэр. Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ. УБ., 1987.

The formation and development of the statehood and state service

By D.Dairiimaа

Summary

This article about the origin and formation of the statehood doctrine since the establishment of the Great Mongolian State in 1206. The author concluded that the united state, established by Chinggis Khaan, had a doctrine, how to choose, to train, to develop to evaluate the state officials, which they were able to implement in live.